

II ХЭСЭГ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Доктор (Sc.D), профессор Ц.БАЛХААЖАВ

2.1. МОНГОЛ МАЛЧНЫ ТУХАЙ СУДАЛГААНЫ ТОЙМ

Түлхүүр үг: хүний үүсэл, монгол хүн, нүүдэл иргэншил, монгол малчин, монгол малчны хэв маяг

Товчлол. Энэ өгүүлэлд хүний үүслийн тухай хувьслын онол, Монгол нутагт хүн үүссэн хийгээд монгол хүн гэгч хэн бэ гэдгийг юуны өмнө хураангуйлан авч үзээд, монгол хүний гол төрх болсон монгол малчны тухай онцлон өгүүлсэн байна. Ийнхүү хүний хөгжлийн монгол загварыг нүүдэлч малчны дүр төрхөөс өөрөөр үзэхийн аргагүй хэмээн зохиогч үзэж, монгол малчны нийгмийн түүхэн шинж, хэв маягийг тодорхойлжээ. Философийн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Балхаажав өөрийн олон жилийн ажиглалт судалгааны үр дүнгээсээ эл өгүүлэлд дүгнэлт бодролын хэлбэрээр тоймлон илэрхийлсэн байна.

Монгол газар нутагт Монгол хүн оршин аж төрж ирсний анхны үүсэл гарал эрт дээр үеийн уг сурвалжтай. Түүхчдийн дүн шинжилгээ, археологийн олдворын хугацаа улам бүр урагшилж, одоогоор 750 мянган жилийн тэртээд очоод байгаа. Энэ бол бидний бодит баримтад тулгуурлаж буй цаг хугацааны нэгээхэн хэмжүүр.

Монголын нутаг дэвсгэрийн геологи үечлэлийн болон газар зүйн ерөнхий тогтоцын шинж, өвс ургамал, ан амьтны төрөл зүйлийг бүхэлд нь бодож үзэхэд монгол хүний үүсэл гарлын он тооллын хэмжээ өнөөгийн бидний мэдэж нотолж байгаагаас цаашилж болох бүрэн үндэс буй.

Хүн дүрст сармагчин өвөг удмаасаа хүн төрөл тасран салах болсон үйл явц бол тав, арван мянган жилийн шинжтэй бус билээ. Горилло, урангутан мэт сармагчны уураг тархины жин 750-800 грамм орчим байгаад хүний төрөл рүү тэр жин грамм граммаар нэмэгдэх, энэ хэмжээг дагалдан хүнд сэтгэх мэдрэлийн ганц нэг эс, чадавхи нэмэгдэх, амьдрах хөдөлмөрийн өчүүхэн арга шинж өөрчлөгдөх зэрэг нь тэр үедээ эволюци хувьслын хуулиар бол мөн ч урт хугацаа буйзаа. Энэ жам хуулиас гаднуур Монгол хүнийх яваагүй нь мэдээж хэрэг. Монгол хүний үүсэл гаралыг хүн төрөлхтөний үүслийн түгээмэл зүй тогтлоос ангид авч үзэх үндэс огт байхгүй.

Хүн судлалын ухааны өнөөдрийн төвшинд хүн чухам хаана, хэдүйд, яаж үүсэх болсныг нарийн тогтоож, хөдлөшгүй нотолж чадаагүй, сайндаа л эрдэмтэд таамаглал

дэвшүүлж байгаа нөхцөлд хэсэг Монголжуу нь Монголд, хэсэг Европжуу нь Европын аль нэг нутагт, хэсэг Африкжуу нь Африк тивийн аль нэг газарт үүсчээ гэж салгаж өгүүлэх буюу эсвэл хаа нэг нутагт хүн үүсээд манай гаригийн өнцөг булан бүрт тархан нүүдэллэж, сууршжээ гэж баттай хэлэх арга алга.

Тиймээс хамгийн хялбараар нь хүнийг бурхан буй болгожээ, хүн анх харь гаригаас нүүдэллэн иржээ гэх буюу үлэг гүрвэлээс ч гарсан байж магадгүй гэх бэлэн санаа шидэгдэх явдал буй.

Миний хувийн хатуу үнэмшил, ойлголтоор бол Монгол хүн бусдын нэгэн адил хөдөлмөр, сэтгэхүй хоёрын нэгдмэл ажиллагааны ачаар хумхийн бичил тоос-усаар бол бичил дусал, оюуны бол бичил эсийн хуримтлал болон үүсч аажим аажмаар хөгжиж ирсэн нь лавтай. Хөгжлийг түүний дотор Монгол хүний хөгжлийг бид хэтэрхий хялбарчилж ойлгодог учраас Монгол хүнийг зөвхөн өнөөгийн бэлэн хүний дүр төрхөөр төсөөлж ойлгох дуртай билээ.

Монголын үндэсний музейд байгаа түүхэн үзмэр, архелогийн олдвор, хуучин, дунд, шинэ чулуун зэвсгийн үе гэдэг ангилал, зэс, хүрлийн болон төмөр зэвсгийн үе гэдэг ангилал бол Монгол хүний өвөг дээдсийн хүн удмын намтар дэндүү богинохон, тун хожмын шинжтэй байж таарах гээд байгаа юм.

Хүний үүсэл хөгжлийн замналыг хамгийн том макро төвшинд хэд хэд хуваан ангилж болох юм. Жишээ нь:

1. Сармагчин төрөл нь зонхилж байсан үе
2. Хүн төрлийн шинж нь түрж эхэлсэн үе
3. Хүн дүр төрх нь давамгайлсан үе
4. Орчин үеийн хүн шинж бүрдсэн үе

Эдгээр үе ангилал Монгол хүнд нэгэн адил хамаарна. Монгол хүнийг антроплогийн шинжлэх ухааны үүднээс био болон нийгмийн хувьд танин мэдэж буй бидний мэдлэг чухамдаа дээрх ангиллын сүүлийн хоёр үеийн ерөнхий мэдэгдэхүүний хирд л байгаа юм уу даа. Монгол нутагт хүн оршиж байсныг 750 мянган жилийн тэртээх хүн гэсэн тодорхойлолтоор нотолсон авч нарийвчилсан судалгаа энд хараахан гараагүй. Орос эрдэмтэн А.П.Окладниковын судалгаагаар манай Дундговийн Ярх, Дорноговийн Сайн-Шанд, Өмнөговийн Маньт зэрэг газраас эртний Синантроп үеийн хүний араг яс, гар хийцийн чулуун эдлэл олдсон гэдэг. Мөн неандертал үеийн бүдүүлэг чулуун эдлэл олдсон. Бас Төв Монголын нутгаас нум,

сум, хурцалж ирэлсэн чулуун хутга, шавар эдлэл олсон байдаг. Гэхдээ эдгээр нь палеолит, мезолит үеийн тухай олдвор.

Неолит буюу шинэ чулуун зэвсэг гэгдэх үед барьсан гэхээр орон сууц маягийн зүйл, булш оршуулгын байдалтай олдвор байдаг. Энэ мэтийг манай тооллын өмнөх 500 мянгаас нааш арваад мянган жилээс цааших хугацаанд хамааруулан үздэг. Энд соирхолтой нь ирээдүйд Монгол хүн болох нэн бүдүүлэг хүнд цэвэр байгаль-инстинктээс хүн инстинкт он жилээр сууж, амьдрах тэмцэлд нь хөдөлмөрөөс хөдөлмөр ургаж, шинэ бүхэн нь удамшин үлдсээр тухайлбал гар хуруунаас багаж хэрэгслийн, сав суулгын, бэлэн байгаль бүтээгдэхүүнээс өөрт илүү тус хүргэх иртэй, үзүүртэй чулуу арай дээрийг мэдрэх мэдлэг, хийх арга, юунд түүнийг хэрэглэх санаа төрдөг болсныг хэн үгүйсгэх билээ.

Энэ бүх явцад хүний бүх эрхтний хөгжил, зохицол, жишээ нь хөл нь босоо явахын бүх шаардлага хэрэгцээг, гар нь чөлөөтэй ажиллахын, нүд нь холыг харахын, чих нь дуу чимээний өнгө ялгахын, хоолны амт ямар байх, дуу хоолой, хэл яриагаар холбоо барихын чухлыг алхам, алхамаар мэдэж чадахад хэдүй бүдүүлэг, эв хавгүй боловч бие сэтгэхүй дасаж боловсронгуй болно. Өнөөх аугаа их биологич эрдэмтэн Ч.Дарвин, аугаа их нийгэм болон түмэн бодис судлаач, философич Ф.Энгельс нарын нотолгоо, дүгнэлт ёсоор л Монгол хүний ч түүхэн хөгжил болсон гэдгийг хэлэх явдал шинжлэх ухаанд нийцтэй болно.

Монгол нутагт хүн оршиж, аж төрж ирсэн гэх хугацаа хичнээн уртсах тутам түүний сармагчин удмаасаа хойших хөгжлийн бүх явц нь аажим хувьслын байгаль шалгавар, хүнтэй цуг хүнийг хүн болгон хөгжүүлдэг хөдөлмөрийн зайлшгүй үр дүн мөн.

Шинэ чулуун зэвсэг, хүрэл зэс багаж хэрэгсэл, төмөр эдлэлийн гэж түүхчдийн тодорхойлдог шинжүүдийг Монгол хүнтэй холбон бодвол хадны сүг зургууд, нум, сум, хутга мэсийн зүйл, мал адгуусны дүрс, янз бүрийн хээ угалз, хүний дүр төлөв мянганаас дамжин бүүр илэрхий болдог. Эрт дээр үед гол төлөв амьдралын ойр зуурын хэрэглэлийн шинж ойлгогддог байсан бол сүүл рүүгээ амьдралын олон тал, сэтгэн бодохуйн шууд болон далдын хийсвэр талууд улам ихсэж байна.

Манай тоололд ойртох цаг хугацааны мөч бүрт орон зайн цар хүрээ өргөсөн тэлэх тутамд, ойролцоогоор 30 мянган жилээс өнөө рүү наашлахын хирээр Монголчууд ураг төрлийн холбоо нь төдийгүй этно бүлгүүдийн нэгдэл, хамтын зүтгэлийн арга хэлбэр нь оршин ахуйн ялгуур үндсийг олон талт эрэл, хувилбарт

оруулах болжээ. Ховдын Манхан сумын Хойд цэнхэрийн агуй дахь хадны зураг, Дорнодын Тамсагбулаг дахь газар доори орон сууцны үлдэгдэл, Өмнөговийн Баянзагийн ясан хутга, газар сайгүй олдох болсон шавар, чулуу, хүрэл, зэс эдлэл, зураг, баримал мэт зүйлсийн цаана эд бүгд нь хүнээс хүнд, айлаас айлд хэлбэр, санаа сэтгэмжийг энд тэндгүй зэрэг зэрэг олж мэдэх болов уу гэдэг нь үнэхээр сонин асуудал билээ.

Бид бүхний түүхийн болон философи, сэтгэлгээ, логик болон ургуулан төсөөлөх бодол санаа, нэг бүрчлэн задлан шинжлэх болон нэгтгэх дүгнэх судалгаанд дээрх материал нэгийг шууд хэлж, нөгөөд санаа сэдэх зүйл болох учиртай.

Нэгэн баримтыг иш татъя. Одоо, Америк тивд цөөвтөр болж үлдсэн индиан угсаантны өвөг дээдсийг Монголоос гаралтай гэдэг дүгнэлт дээр зөвхөн антропологичид бус, түүхийн ухааны олон эрдэмтдийн санаа нийцэж ном зохиолд тусгагдаж байгаа. Монголжуу омогт багтах болсон тэр хүмүүсийн Америк тивд Берингийн хоолойгоор нэвтрэн очсон хугацааг зарим эрдэмтэд 40-30 мянга, зарим нь 10-аад мянган жилийн тэртээх настайгаар таамаг дэвшүүлэн өгүүлдэг. Үүнийг философичид бид юуны урьд боломж талаас нь, түүнчлэн цаг хугацаа, орон зай, өөрчлөлт хөгжил талаас нь авч үзэхийг зорилго болгодог.

Хүн гэдэг их хорвоогийн үүсэл хөгжлийн зүй жам нь төрсөн цагаас хөдөлмөр, соёл, мэдлэг, ёс суртлын цогцолбор байдаг болохоор эдгээр шинжийн түүхэн холбоо монгол хүн, индианчуудын хооронд бусдаас илүү байсан болов уу гэдэг сэтгэгдэл төрүүлдэг. Харин хэл ярианы учир холбогдол зэргийг хэл болон угсаатны зүй судлаачид л илүү тайлбарлах болно. Индианчуудын нүүдлийн үед Монгол хэлний тогтоцын асуудал ямар байсан бол, мөн ураг төрлийн холбоо, эхчлэх, эцэгчлэх ёс ямар байгаа бол гэсэн бодол бас төрдөг билээ. Энд бас орос болон дундад, төв азийн бусад зон олны намтар түүх, ялангуяа скиф төрлийнхөн, дорнод Сибирь, Байгаль нуур хавийн отог, омог, угсааны этно холбогдол ямар болохыг сайтар шинжлэн тогтоох явдал чухал ач холбогдолтой.

Монгол хүн ерөөс хүн заяаны хувь тавилангаа нүүдлийн мал аж ахуйтай үүрд холбож, малчин удамт хүн болж олон мянганы түүх бүтээж ирсэн явдал хүн төрөлхтөний иргэншлийн нэгэн томоохон асуудал, өвөрмөц нарийн үйл явц билээ. Соёл болон иргэншлийг эрдэмтэд хичнээн янзаар тодорхойллоо ч нүүдлийн соёл болон иргэншлийн үр хөврөлийг тавьж өдий хүртэл агуулан яваа нь Монгол хүний түүхэнд оруулсан хувь нэмэр юм.

Монгол хүнийг ерөөс аж ахуйн бусад хэлбэрт холбогдолгүй олон он жил туулсан гэвэл худал болно. Баянхонгор аймгийн Бичигтийн ам хэмээх говь нутагт манай тооллоос бүр өмнө газар тариалан эрхэлж байсан ул мөр болох эртний зарим багаж, хагалж байсан газрын хөрс шороо, тэр байтугай зарим газар үр тариа боловсруулахдаа чулуун тээрэм хэрэглэж байсан байна гэхээр байдаг ажээ. Түүнчлэн гар урлал, уран дархны ажил ч дээр үеийн гаралтайгаа нотолдог.

Зэрлэг ан амьтныг удаан хугацаанд хүн биедээ дасгаж гэрийн болгож ирсэн үеэс малчин гэдэг нэр томъёоны язгуур үндсийг гаргах болов уу. Эрдэмтэд, ялангуяа түүхчдийн тодорхойлж байгаагаар бол хүний мал маллах арга ажиллагаа манай тооллын өмнөх 4.5 мянган жилийн тэртээд мэдэгдэхүйц шинжээ олжээ. Хэрэв тийм бол наад зах нь одоогоос 7-8 мянган жилийн намтартай уртаас урт зам малчин нэрийн цаана гарна.

Малчин гэсэн энэ үгийн хүрээнд хүний үйл амьдралын маш олон бөгөөд утга агуулгын өргөн цар бүхий удам угсаа, аж төрөх, арга ухаан, сэтгэл зүй, ёс заншил, үр бүтээлийн шинж төрх багтана.

Монгол малчин хэмээн нэрийн ойлголт, утга агуулгын дотор бэлчээрийн мал аж ахуйг олон мянган жилийн үе удам дамжин эрхэлж, эзэгнэж ирсэн Монгол хүнийг өгүүлж байна. Энэ хүн бол нүүдэлчин амьдралтай бөгөөд байгаль, цаг уур, өвс ургамал, ус, эрдэс бодис, малын эмгэг өвчин, малын зан чанар, ашиг шим, үржлийн талаар практик өндөр мэдлэгтэй. Тэрбээр таван төрөл (адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа) малын эзэн, өмчлөгч, малыг хариулан маллаж үржүүлэн өсгөгчийн хувьд шууд үйлдвэрлэгч, арьс шир, ноос үс, сүү шимийг боловсруулан бүтээгдэхүүн хийдгийн хувьд өөрийн хэрэгцээг хангагч бөгөөд бусдад зориулан таваар үйлдвэрлэгч, малаа уналга, ачлаганд сурган тээвэрт ашиглагч, илүү бүтээгдэхүүнээ борлуулагч наймаачин, хувцас хунар, гэрийн бүрээс ширдэг, оосор бүчээ бэлтгэдэг оёдолчин, нэхмэлчин, орон сууцаа үйлдэж, засч сэлбэн авч явдаг барилгачин, зохион бүтээгч, уртын дуу, морин хуурын эгшиг, шүлэг найраглал, намтар түүхээ туурвиgч яруу найрагч, түүхч, биеийн тамир спортын үндэсний өвөрмөц хэлбэрийг үүдэн гаргагч тамирчин мөн.

Монгол малчны нийгмийн шинжийг үндсэнд нь малаа эртний чөлөөт болон овог аймгийн эзэмшлээр эрхэлж явсан үе, монголд төрт ёс тогтож хөгжсний эхний болон дундад үе, ардын төрийн мэдэлд хувийн ба хоршооллын малын эзэд байсан үе, зах

зээлийн харилцааг дагнах болсон үе гэсэн дөрвөн томоохон үечлэлд хамруулж болно.

Монгол малчны нийгмийн түүхэн шинж, түүний цаашид аж төрөх дүр төлвийн талаар зарим дүгнэлтийг хийж болно.

1. Монголын малчин нэрийн цаана мал маллаж аж төрөх арга ухаан, сэтгэл зүй, ёс заншил, үйл бүтээлийн наад зах нь 7-8 мянган жилийн намтар бий. Монгол нутагт хүн үүсэн, аж төрж байсан тухай археологчид, түүхчдийн нотолж буй хэдэн зуун мянган жилийн хугацаатай жишвэл малчны намтарын цаг нь өчүүхэн богино хугацаа юм. Энэ хүмүүс хээрийн амьдралаар уул аж ахуйг хөтлөж нүүдэлчдийн иргэншлийн эхийг тавигчид болсон. Тэр байдал өнөөг хүртэл уламжлагдаж иржээ.

2. Анчин амьдралаас үүдэн зарим анг аажмаар гэршүүлж, гэрийн тэжээмэл таван төрөл мал сүргийг сонгон авч голлон эрхэлсэн цагаас хойш Монгол малчны анхны чөлөөт, мөн отог омгийн малчнаас төрт ёсны түүхэн намтрын 2200-аад жилийн малчин намтрыг туулахдаа 24-25 нэрийн нийгмийн шинж бүхий малчин удам дамжжээ. Төрт ёсны үеийн гэхэд энд хаад, ноёд, жас, жавын мал маллагчид, өөрийн малтай малчин, гадаадын ноёрхогчдын мэдлийн, нэгдлийн, сангийн аж ахуй, хувийн гэх мэт нэр, шинж багтана.

3. Бүтцийн хувьд хувиа аргацаасан, ядуу, дунд, чинээлэг баян, байршлын хувьд хангайн, өндөр уулын бүсийн, хээр талын, говийн, харъяаллын хувьд урьд бол эзний, тамгын, жасын одоо бол сум, баг, хариуцагчийн, хариуцлагын хувьд төрөлжиж таван хошуу мал нэгэн зэрэг, төрөл төрлөөр тус тус маллагч (тэмээчин, адуучин, үхэрчин, хоньчин, ямаачин, нэг наст малын малчин), мөн ангиллын хувьд тэргүүний, сайн, баатар, аварга малчин, мэнд сүрэгтэн, мянган малтан гэх мэт хуваагддаг байсан ба байгаагын цаана утга агуулгын, нэр хүнд, үүргийн холбогдолтой олон шинж тодорч байдаг.

4. Монгол малчин бол бэлчээрийн мал маллах, арга, үйлдвэрлэл явуулах технологи, ус цаг уур, ургамал танин, байгаль орчинтой зохицох, түүнийг танин мэдэх мэдлэг, малын тэжээл, байршил, өвчин эмгэг, үүлдэр угсааны оронд төдийгүй дэлхийд нүүдлийн иргэншлийн хэлбэрийг бүхэлд нь боловсруулан авч яваа асар том хүч мөн. Энэ утгаараа бие даасан нүүдлийн соёл болон иргэншлийн жинхэнэ эзэн нь мөн.

5. Малчныг өнөөгийн Монгол орны суурьшмал амьдралын өвөг эцэг, энэ амьдралыг тэжээгч том үйлдвэрлэгч хүч, Монгол уламжлал, ёс заншил, ахуйн

нөхцөлийг хадгалан баяжуулагч, аж төрөх арга ухаанаа шинээр төвхнүүлэн авч яваа орчин үеийн нүүдэлчин бөгөөд боловсролтой иргэн гэж үзнэ. Хүн амд 170 мянган өрхийн хүрээнд 390-ээд мянган үйлдвэрлэгчийг хамарч байна. Түүний үйлдвэрлэлийн үндсэн хөрөнгө мал юм.

6. Энэ монгол малчнаас олон өөр хүн төрж нийт монголын нэр алдарыг өнөөг хүртэл бадрааж явна. Тэдэн дотор Модун Шанью, Чингис хаанаас эхлээд олноос олон хаад, ноёд, язгууртан, эрдэм оюуны мөр хөөсөн мэргэд, лам хувраг, авъяас билэгтэн, манай орчин үе гэхэд хатан баатар Магсаржав, Дамдины Сүхбаатар зэргийн жанжинууд, ерөнхийлөгч, ерөнхий сайд, мэргэжлийн багш, эмч, жолооч, нисгэгч, инженер, дипломатчдын хэд хэдэн үе өнгөрсөөр гурав дахь мянган, 21 дэх зуунтай Монголын тусгаар тогтносон, ардчилсан бүгд найрамдах улс золгожээ.

Хүний хөгжлийн монгол загварыг ерөнхийд нь нүүдэлч малчны дүр төрхөөс өөрөөр үзэх боломжгүй. Гэвч энэ нь нийт хүн төрөлхтөний үндсэн шинжүүдээс ойцгойлох зүйл бас биш ээ. Хүний нийтлэг хөгжлийг чадавхи чадварын хоёр гол ангиллаар авч үзэх арга монгол хүн дээр ч нэгэн адил холбогдоно. Монгол хүний удам дагасан бие, оюуны уламжлалт төрөлх цэнэг нь чадавхийн хүрээнд хамаарна. Монгол хүн дотроо ураг төрлийн холбоог буюу овгийн холбоог "Яс махны тасархай" гэсэн оновчтой үгээр илэрхийлдэг. Энэ бол түүний цусан төрдлийн удам угсааны ямар чансаа чадавхийг залгамж чанарын ялгааг хадгалж буй хэрэг. Харин яг энэ нас, энэ бие дээр нэр тэр чанарт нэмж байгаа шинэ хүчийг бид чадвар гэж нэрлэхийг оновчтой гэж үздэг. Энэ чадвар бол хэний ч бай ер нь хүний, түүний дотороо монгол хүнийг баяжмал шинэ хүн болгож буй билээ. Учир нь хөдөлмөрийн арга туршлага олж авах, эрүүл мэнд, боловсрол, соёл хүмүүжил зэрэг нийгэм иргэншлийн бүх үзэгдэл үйлдэл нь хүнд орчноос болон өөрөөс олдмол чанарыг бий болгоно. Энэ хувьдаа хүн бол цэвэр "би" биш болдог. Түгээмэл зүй жамын гадна талд монгол хүнээ тавих аргагүй. Энэ хувьдаа ч монгол хүн цэвэр монгол "Би", "би биш", дэлхийн хүн ам болох жамтай. Үүгээрээ ч түүнийг дэлхийн буюу манай гарагийн хүн гэдэг түгээмэл том нэрийн доторхи нэг бяцхан тусгал, салшгүй нэг эд эс нь гэж үзэх үндэстэй.

Шинжлэл судлалын үүднээс жаахан лавшруулж бодвол, өнөөгийн монгол хүнийг нэгэн отог омог, ураг төрөл, овгийн шинж чанараас гений хувьд ч бие, оюуны уламжлалт чанарын хувьд ч хүн орчны нийтлэг хүрээнд ч улам бүр шингэн шилжиж явна гэмээр сэтгэгдэл төрдөг. Үүнийг монгол хүн монгол төрхөө алдах тийшээ оржээ

гэсэн дүгнэлт болгон ойлгож хараахан болохгүй. Яагаад гэвэл, ийм чанарын өөрчлөлт бол хүн шинжийн хөгжилд урт хугацаа шаардах үйл явц билээ.

Хөгжлийн төвшний тухайд чадавхийн хувьд ч чадвар эзэмшихийн хувьд монгол хүн бусад тивүүд, улс орны хүнээс онцгойлон авч үзэх хоцрогдолгүй. Шинэ зууны төвшинд хэнтэй ч эн зэрэгцэн ойлгогдох хүүхэд, насны өсөлт, дунд насныхны ажил хөдөлмөр, бие, оюуны хүч, ахмад насанд аж төрөх арга сургамж бий.

Эдүгээ манай гараг дээр монголчуудад шууд хамаарагдах гарал үүсэл, нэгтэй, хэрэв Америкт эрт цагт нүүдэллэн очсон гэгдэх индианчуудын хамт 10 сая орчим хүн байгаагийн 2.5 сая нь монгол нутагтаа тусгаар тогтносон улсын монголын ард түмэн нэртэй, НҮБ-д гишүүнчлэлийн эрх эдлэн дэлхийн олон улстай эрх тэгш оршин аж төрж байна.